

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 3 ДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

2025 оны 09 дүгээр сарын 24

Багануур дүүрэг

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв сая төгрөг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1. Багануур хүнд үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана. МУЗГҮАХ 2024-2028 1.2.1.3, НЗДҮАХ 2024-2028 3.3.1, 3.3.2, НХТЖҮЧ-4.3.3, НХТ-230, 231							
Зорилт 1. Батлагдсан зураг төслийн дагуу дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд шаардлагатай санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлүүлэх, бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх. НХТ-230							
1.1	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76 км өндөр хүчдэлийн агаарын шугамын бүтээн байгуулалтын ажлыг дуусгах	Нийслэлийн төсөв 300.0	Ажлын гүйцэтгэл, хувь	90	100	<p>2022-2024 онд Нийслэлийн төсвөөс нийт 1,874.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 110кВ-ийн 6.76 км урт ЦДАШ-ын бүх суурийн ажил хийгдэж, эхний анкер тулгууруудыг босгож дууссан.</p> <p>2025 онд бүтээн байгуулалтын үлдэгдэл 300.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/197 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар (НХОГ)-т шилжүүлсэн.</p> <p>НХОГ-ын 2025 оны А/21 дугаар тушаалын дагуу 2025.03.14-ний өдөр Паркийн үндсэн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76км цахилгаан дамжуулах агаарын шугамыг Эрчим хүчний барилга байгууламжаар бүртгэн ашиглалтад оруулахаар дараах байгууллагуудын төлөөллийг оролцуулсан техникийн комисс ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Захиалагч: НХОГ ОНӨААТҮГ ▪ Зургийн автор: Мон-Энержи Консалт ХХК ▪ Гүйцэтгэгч: Энх өглөө ХХК ▪ Өмчлөгч: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК ▪ Ашиглагч: БҮТП ХК ▪ Месес ХХК <p>Техникийн комисс нь улсын комисс ажиллуулахаар шийдвэрлэж дараах бэлтгэл ажлуудыг хангуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ▪ 220/110/35кВ-ын Багануур дэд станцын өргөтгөл, гаргалгаа, релэй хамгаалалт, удирдлагын панель, угсралтын ажил ▪ Шилжүүлэг ажлын хүрээнд таслалт хийх хүсэлтийг ашиглагч байгууллагад хүргүүлэх 	100

						<ul style="list-style-type: none"> Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн зөвлөмжийн дагуу зарим шаардлагатай тоноглолыг захиалан угсрах <p>Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын цахилгааны хэлтсийн дарга Д.Батзоригоор ахлуулсан Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэсэн.</p>	
1.2	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай үндсэн дэд станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Нийслэлийн төсөв 1,048.9	Ажлын гүйцэтгэл, хувь	0	10	<p>110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын нийт төсөв 9,911.6 сая төгрөг бөгөөд Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 50% буюу 4,955.8 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 1,048.9 сая төгрөг тусгагдан батлагдаж дараах шатанд ажил явагдаж байна.</p> <ul style="list-style-type: none"> Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нээгдэж оролцогч 3 байгууллага шаардлага хангаагүй тул Багануур үйлдвэрлэл технологийн паркийн дэд станцын ажил, 110/35/10кВ-ын НХААГ/20250101634/02/01 урилгын дугаартай тендерийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүртэл дахин зарласан. Гүйцэтгэгчээр Эм Ай Эс Эс ХХК нь шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан. 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр “Эм Ай Эс Эс” ХХК-аас дэд станцын бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан газар дээр ирж ажилласан бөгөөд ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох байгууллагад хүргүүлсэн хүлээгдэж байна. 	60
Зорилт 2. Багануур үйлдвэрлэл технологийн паркийн “Захиргаа нэгдсэн үйлчилгээний төв” барилга худалдан авах. НХТ-231							
2.1	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн “Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилга худалдан авах	Нийслэлийн төсөв 700.0	Ажлын гүйцэтгэл, хувь	0	100	<p>Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг барих ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> Паркийн өмчид Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн хуучин тал барилга байдаг бөгөөд үлдсэн тал барилгыг худалдан авах төсөв 700.0 сая, засвар хийж 	0

						<p>ашиглалтад оруулах төсөв 2,329.0 сая, нийт 3,029.0 сая төгрөгийн төсөвтэй ажил юм.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 60% буюу 1,740.0 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 700.0 сая төгрөг тусгагдсан. ▪ Нийслэлийн Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад нийслэлийн 2025 оны төсвийн 80 дах заалтад батлагдсан Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилга худалдан авах 700.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр уулзаж 2025.02.06-ны өдрийн 36 дугаар, 2025.02.13-ны өдрийн 42 дугаар албан бичгүүдийг хүргүүлсэн боловч нийслэлийн төсвийн тодотголоор дахин хэлэлцэгдэж хасагдсан тул уг арга хэмжээ 2025 оны 03 сард хэрэгжих боломжгүй болсон. 	
2.2	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн "Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилга угсралт, их засварын зураг төсөл боловсруулах, батлуулах, хөрөнгө оруулалтын саналыг хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэх		Ажлын гүйцэтгэл, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> ▪ Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар Паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төслийн 35.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж "Нутаг консалтинг" ХХК нь зураг төслийг гүйцэтгэж 2020 онд хүлээлгэн өгсөн байдаг. ▪ Тус барилгыг барихад шаардлагатай 2,454.2 сая төгрөгийг тусгуулахаар дараах саналуудыг хүргүүлсэн. <ul style="list-style-type: none"> ○ Монгол улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 1 сард, ○ Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд 3 сард, ○ Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 6, 8 сард, ▪ Мөн 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 135 дугаар албан бичгээр 2019 оны зураг төслийн төсвийг шинэчлэх хүсэлтийг "Нутаг консалтинг" ХХК-д хүргүүлж, онлайн хурал зохион байгуулсан. ▪ "Нутаг консалтинг" ХХК-аас 3.0 сая төгрөгөөр төсөв шинэчлэх боломжтой тухай саналыг ирүүлсэн тул төсвийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. 	100
<p>Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ. "Багануур үйлдвэрлэл технологийн парк"-ийн салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд дэвшүүлсэн төрийн бодлого, шийдвэр, парктай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акт, дүрмээр тогтоосон чиг үүрэгтэй уялдуулах, чиг үүргийг хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулах, зохицуулах, зохион байгуулах, боловсон хүчнийг бүрдүүлэх, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангаж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллах</p>							

3.1	<p>Паркийн тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бичгийг боловсруулж, тусгай зөвшөөрөл авах ажлыг шийдвэрлүүлэх</p> <ol style="list-style-type: none"> 1. Паркийн нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл 2. Паркийн хөгжлийн төлөвлөгөө 3. Паркийн нэгжийн техник, технологийн түвшний үнэлгээ 4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ 5. Гэрээ байгуулах паркийн нэгжийн жагсаалт 	-	Тусгай зөвшөөрөл	0	100	<p>Эрдэм шинжилгээний байгууллагаар Паркийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд дараах 3 байгууллагаас үнийн санал авах хүсэлтэй уламжлан уулзалт зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т 2025.05.30-ны өдрийн 80 дугаар албан бичгээр хүсэлтээ уламжлан уулзсанаар 2025.06.10-ны өдрийн 01/305 дугаар хариу албан бичгээр үнийн саналыг хүлээж авсан. ▪ 2025.06.03-ны өдөр Монголын паркуудын холбооны тэргүүн Р.Батгэрэл, Гүйцэтгэх захирал О.Өлзийбаатар нартай уулзаж паркийн хөгжлийн төлөвлөгөө, ТЭЗҮ шинэчлэх зэрэг асуудлыг хэлэлцэн 2025.06.06-ны өдөр үнийн саналыг хүлээн авсан. ▪ 2025.06.13-ны өдөр ШУТИС-ийн ЗУГ-ын дарга Түмэндэлгэртэй уулзаж Хөгжлийн төлөвлөгөө, ТЭЗҮ шинэчлэх 2024 онд өгсөн 400,0 сая төгрөгийн үнийн санал дээр ярилцаж, 2025.06.13-ны өдөр 87 дугаар албан бичгээр Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар дээр үнийн санал өгөхөөр ярилцаж, 2025.06.19-ний өдрийн 131 дугаар бичгээр үнийн саналыг хүлээн авсан. <p>ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний үнийн саналыг танилцуулан дэмжлэг хүсэж 2025.06.24-ны өдөр дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ 101 дугаар албан бичгээр – НЕА Ч.Төгсдэлгэр ▪ 102 дугаар албан бичгээр – УИХ гишүүн Б.Уянга ▪ 103 дугаар албан бичгээр – Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ ▪ 104 дүгээр албан бичгээр – Нийслэлийн ЗДТГ-ын дарга Д.Амгалан ▪ 105 дугаар албан бичгээр – Эдийн засаг хөгжлийн яам <p>Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1130 дугаар Эрх шилжүүлэх тухай захирамжийн хавсралтаар Хөгжлийн төлөвлөгөөний 40.0 сая, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах 40.0 сая буюу нийт 80 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан.</p> <p>Захирамжийн хэрэгжилтийг ханган ажлын даалгавруудыг боловсруулан, холбогдох дээд шатны байгууллагуудаас санал авч тусган Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэн ажилласан. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо байгуулагдсан байгаа бөгөөд тендер зарлахыг хүлээж байна.</p>	50
-----	--	---	------------------	---	-----	--	----

						<p>Паркийн нэгж үйлдвэрээс байршихаар санамж бичиг байгуулсан дараах үйлдвэрүүд нь Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, батлуулахаар ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Натур ларикс вүүд ХХК ▪ Мах маркет ХХК ▪ Үнэт дулаан ХХК ▪ Трий Трийлэнгс Ойл ХХК 	
3.2	<p>Нийслэлд боловсруулах үйлдвэр байгуулах болон түүнтэй холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр ашиглаж буй төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах</p>	-	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	0	100	<p>Хятад улсын 100% хөрөнгө оруулалттай “Дөл түшиг майнинг” ХХК-ийн “Багануур ган” төслийн хүрээнд дараах ажил хийгдэж байсан бөгөөд компанийн удирдлага солигдсон тул зогсонги байдалтай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ 2025.01.06-ны өдрийн 03 дугаар албан бичгээр “Дөл түшиг майнинг” ХХК-д “Багануур ган” төслийн ТЭЗҮ-ийг АҮЭБЯ-ны Эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулах тухай мэдэгдсэн. ▪ 2025.01.20-ны өдрийн 25 дугаар албан бичгээр МУЗГ-ын ХЭГ-ын дарга МУ-ын сайд Н.Учралд хүнд үйлдвэрлэлийн “Багануур ган” төслийг танилцуулгын хүргүүлсэн. ▪ 2025.01.22-ны өдрийн 22 дугаар албан бичгээр Эрдэнэс монгол нэгдэлд “Багануур ган” төслийг танилцуулга болоод түүхий эдийн хангамжийн талаар саналыг хүргүүлсний дагуу Эрдэнэс монгол нэгдэл нь 2025.01.27-ны өдөр 07/99 дугаар хариу албан бичгээр уулзаж танилцуулах шаардлагыг ирүүлснийг паркийн зүгээс “Дөл түшиг майнинг” ХХК-д дамжуулсан. <p>Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсэд “Трий Трийлэнгс Ойл” ХХК нь хүрэн нүүрснээс коксжуулсан нүүрс ба синтетик газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэхээр 2025.07.05 өдөр парктай хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Тус үйлдвэр нь жилд 120 мянган тонн коксжуулсан нүүрс үйлдвэрлэх болон синтетик газрын тос үйлдвэрлэх хүчин чадалтай төсөл хэрэгжсэнээр шинээр 50-84 ажлын байр бий болгоно. Төслийн ТЭЗҮ-г боловсруулан Эрчим хүчний яамны зөвлөлийн хурлаар хянагдаж, Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	10
3.3	<p>Бодлогын баримт бичгүүд болон дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангах ажлыг зохион байгуулж, холбогдох дээд</p>	-	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	0	100	<p>Одоогийн байдлаар дараах дээд газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэн хугацаанд нь тайлагнан ажилласан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан ажиллах тухай 03 дугаар албан даалгавар, 	

<p>шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах</p>				<ul style="list-style-type: none"> ▪ Нийслэлийн Засаг даргын 2025.01.02-ны өдрийн А/01 дүгээр захирамж “Бүтээн байгуулалтын жил” ▪ Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025.01.09 өдрийн хуралдааны тэмдэглэл 01, ▪ МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 2025.02.17-ны өдрийн зөвлөмж 03, ▪ НИТХ-ын 2025 оны 25/46 дугаар Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захирлын үндсэн цалингийн дээд хязгаарыг тогтоох тухай, ▪ Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025.05.16-ны өдөр баталсан Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх тухай 03 дугаар тогтоол, ▪ НИТХ-ын 2025 оны 25/106 дугаар Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ▪ Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.06.18-ны өдрийн 01 дугаар Төрийн албаны сахилга, дэг журам хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай албан даалгавар, ▪ Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.07.08-ны өдрийн 03 дугаар Төрийн албаны сахилга, дэг журам хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар, ▪ Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.07.25-ны өдрийн 04 дугаар Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай албан даалгавар, <p>2025 оны 3 дугаар улирлын байдлаар дараах бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд нь тайлагнан ажилласан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ▪ Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, ▪ Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, ▪ Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, ▪ МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, ▪ МУ-ыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, ▪ Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, 	<p>100</p>
--	--	--	--	--	------------

3.4	Улс, нийслэлийн дунд, богино хугацааны төсөл, хөтөлбөрт паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үе шаттайгаар шийдвэрлүүлэх саналуудыг боловсруулан хүргүүлж тусгуулах	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> ▪ Монгол улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд 3 арга хэмжээг тусгуулахаар НЗДТГ-ын Нийслэлийн бодлогын төлөвлөлтийн газрын Дэд бүтэц бодлогын хэлтэст 2025.01.07-ны өдрийн 04 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ▪ Нийслэлийн Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад нийслэлийн 2025 оны хөгжлийн төсвийн 75, 80, 81 дах заалтад батлагдсан санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр уулзаж 2025.02.06-ны өдрийн 36 дугаар, 2025.02.13-ны өдрийн 42 дугаар албан бичгүүдийг хүргүүлсэн. ▪ Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулахаар НЗДТГ-т 2 өдрийн сургалтад 3 албан хаагч хамтран оролцож 2025.03.12-ны өдрийн саналаа нэгтгүүлэхээр өгсөн. ▪ ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний үнийн саналыг танилцуулан дэмжлэг хүсэж 2025.06.24-ны өдөр дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн. <ul style="list-style-type: none"> • 101 дугаар албан бичгээр – НЕА Ч.Төгсдэлгэр • 102 дугаар албан бичгээр – УИХ гишүүн Б.Уянга • 103 дугаар албан бичгээр – Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ • 104 дүгээр албан бичгээр – Нийслэлийн ЗДТГ-ын дарга Д.Амгалан • 105 дугаар албан бичгээр – Эдийн засаг хөгжлийн яам <p>Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1130 дугаар Эрх шилжүүлэх тухай захирамжийн хавсралтаар Хөгжлийн төлөвлөгөөний 40.0 сая, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах 40.0 сая буюу нийт 80 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд дараах 20 тэрбумын арга хэмжээнүүдийн саналыг тусгуулахаар 6, 8 саруудад хүсэлтээ уламжлан ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> ▪ 297,2 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт ▪ Хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн дулаан хангамж ▪ Хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн ус хангамж ▪ Хүнсний үйлдвэрлэлийн бүсийн дулаан хангамж ▪ Хүнсний үйлдвэрлэлийн бүсийн ус хангамж ▪ Адуу брэнд үйлдвэрлэлийн бүсийн дулаан хангамж 	100
-----	--	---	----------------------------------	---	-----	--	-----

						<ul style="list-style-type: none"> ▪ Адуу брэнд үйлдвэрлэлийн бүсийн ус хангамж ▪ Оффисын барилга ▪ ТЭЗҮ шинэчлэх зөвлөх үйлчилгээ 	
3.5	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж, холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> ▪ Компанийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ▪ Нийт албан хаагчдыг дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвд 2025.07 сард “Эрт илрүүлэг” үзлэгт бүрэн хамруулан урьдчилан сэргийлэн ажиллаж байна. 	100
3.6	Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> ▪ “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын статус өөрчлөгдөн, Хувьцаат Компани болсонтой холбогдон ажилтнуудын шилжилт хөдөлгөөн хийгдэж, 5 ажилтан ажлаас халагдсан, 8 ажилтан шинээр ажилд авсан. Шинээр авсан ажилтнуудын хувийн хэргийн бүрдлийг хангасан. ▪ Тайлант хугацаанд үйл ажиллагааны холбогдолтой тушаал 25, хүний нөөцийн холбогдолтой 30 тушаал гарсан. ▪ Хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулж, ажилтнуудтай гэрээ байгуулан ашиглаж байна. ▪ Хөдөлмөрийн дотоод журам, Ажилтны ажил дүгнэх журам, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журам, Баримт нягтлан шалгах комиссын журмыг тус тус шинэчлэн боловсруулж, удирдлагаар баталгаажуулан тушаалын хавсралтаар батлуулж, үйл ажиллагаанд ашиглаж байна. ▪ Компанийн нийт бүтэц орон тооны 14 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, хөдөлмөрийн гэрээнд дурдсанчлан ажилтнуудад танилцуулж, үйл ажиллагаанд мөрдүүлж байна. ▪ Гүйцэтгэх захирлын тушаалаар Ажлын байрны шинжилгээ хийх ажлын хэсэг томилогдож төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Шинжилгээний тайланг 10 сард удирдлагад танилцуулна. 	100
3.7	MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> ▪ MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний 10 гаруй компаниудыг судалж 6 байгууллагаас үнийн санал авч Күэлити ББСС консалтинг ХХК-тай 2025.09.18-ны өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. ▪ Күэлити ББСС консалтинг ХХК нь 3 сарын хугацаанд зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх, 12 сарын хугацаанд 	30

						<p>нэвтрүүлэлтэд хяналт тавих, 2 албан хаагчийг дотоод аудитораар бэлтгэх болон хамгийн бага үнийн саналыг өгсөн тул сонгогдсон.</p> <ul style="list-style-type: none"> Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу 2025.09.22-ны өдрөөс чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажил эхлээд байна. 	
3.8	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг хянаж, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралт журмын дагуу ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулж Гүйцэтгэх захиралд танилцуулсан. Хүний нөөцийн KPI гүйцэтгэлийн үнэлгээний аргачлалыг судалж байна. 	50
3.9	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	Тус арга хэмжээний хэрэгжилт хараахан эхлээгүй байна.	0
3.10	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Байгууллагын дотоод үнэлгээг хийх сургалтад 1 албан хаагч 2025.04.10-ны өдөр хамрагдаж, Гүйцэтгэх захирлын 2025.04.18-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон. Ажлын хэсэг байгууллагын дотоод үнэлгээг хийж 2025.04.15-ны дотор цахим маягтыг бөглөсөн. Үнэлгээний баримтжуулсан мэдээлэл болон дүн шинжилгээ хийгээгүй болно. Стратеги төлөвлөгөө боловсруулах сургалтад 2025.04.17-ны өдөр 3 албан хаагч хамрагдсан. Гүйцэтгэх захирлын 2025.05.19-ны өдрийн А/17 дугаар тушаалаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон. Компанийн 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралт Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмын дагуу боловсруулсан. 2025.08.04 – 2025.08.18 -ны өдрүүдэд Стратеги төлөвлөгөөний саналын хуудсыг авч дээд шатны 9 хэлтсээр хянуулан, санал шүүмж зөвлөмж аван сайжруулалтыг хийж Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажил эхлээд байна. 	100
3.11	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу компанийн жилийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж,	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт болон Засаг даргатай байгуулсан “хуульд заасан зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний хэрэгжилтийн холбогдох заалтын биелэлтийг гарган 	100

	холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах					<p>НӨХГ-т 2025.05.30-ны өдрийн 81 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу жилийн төлөвлөгөөг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 	
3.12	Монгол хэлний тухай хууль, Үндэсний бичгийн хөтөлбөр, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III болон 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хос бичигтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Дүүргийн болон нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулсан сургалтад Бичиг хэрэг, архивын мэргэжилтэн биечлэн хамрагдсан. Монгол бичгийн хэвлэмэл хуудсыг батлуулан хэвлүүлсэн. Хос бичгээр албан бичгээ төлөвлөн ажиллаж хэвшээд байна. 	100
3.13	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ёс зүйн дэд хорооны ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Компанийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын А/09 дугаараар шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. 2025.08.04-ны өдөр Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 	100
3.14	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Жендерийн асуудал хариуцсан хороо байгуулсан. Албан хаагчдын ажил, ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын дотоод журамд тусгасан. Хөдөлмөрийн тухай хуулийн 5, 6, 7 дугаар, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.6 дахь заалтыг тус өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13.2, 19.1.5 дугаар зүйл заалтын дагуу 2025 оны төсвийн тодотголд төсөв батлуулахаар жендерийн хэрэгцээг судлан ажиллаж байна. Албан хаагчдаас холбогдох судалгааг төлөвлөгөөт хуваарийн дагуу авах, судалгааны дүнд шинжилгээ хийж, тулгамдаж буй сэдвээр мэргэжлийн байгууллагаас сургалт авах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна. 	100
<p>Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Компани нь байгаль орчинд ээлтэй, өндөр технологи бүхий аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, импортыг орлох, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байруудыг шинээр нэмэгдүүлэн, нийслэлийн хүн амын болон үйлдвэржилтийн хэт төвлөрлийг бууруулахад тодорхой нөлөөлөл бий болгож, бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг шинэ шатанд дэвшүүлэх зэрэг үндсэн зорилгын хүрээнд дараах дүрмээр хүлээсэн үйл ажиллагааг өндөр түвшинд хэрэгжүүлнэ.</p>							
4.1	“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн удирдах зөвлөл, эрх бүхий албан тушаалтны чиг үүрэг, үйл ажиллагаа, хариуцлагыг холбогдох	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<p>Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл:</p> <ul style="list-style-type: none"> НИТХ-ын 2024.12.04-ний өдрийн 24/17 дугаар тогтоолоор хараат 6 гишүүн томилогдсон бөгөөд 2025.01.27-ны өдрийн 25/18 дугаар тогтоолоор 2 гишүүнийг чөлөөлж, өөрчлөн томилсон. 	100

	хууль, тогтоол, журамд үндэслэн уялдаа холбоог хангаж ажиллах				<ul style="list-style-type: none"> ▪ НИТХ-ын 2025.02.26-ны өдрийн 25/33 дугаар тогтоолоор хараат бус 3 гишүүн томилогдож Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн бүрэн бүрдсэн. ▪ ТУЗ-ийн 2025.01.16-ны өдрийн 01 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дарга П.Хадбаатарыг томилсон. ▪ ТУЗ-ийн 2025.01.16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мичид-Эрдэнийг томилсон. ▪ ТУЗ-ийн 2025.02.18-ны өдрийн 10 дугаар тогтоолоор компанийн Гүйцэтгэх захирлаар Б.Бямбацэцэгийг томилсон. <p>2025.01.30-ны өдрийн 04 дугаар тогтоолоор НИТХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болгон баталж, мөрдөн ажиллаж байна.</p>	
4.2	<p>Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим, үйлдвэрлэлийн чиглэлүүдийг барьж ажиллан олон улсын болон дотоодын хөрөнгө оруулагчдын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж гэрээ, санамж бичиг байгуулах, шинэ инноваци үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд санал санаачлага гарган ажиллаж паркад шинээр 2 нэгж элсүүлэх</p> <ul style="list-style-type: none"> • Хүнд үйлдвэрлэл • Хүнсний үйлдвэрлэл 	-	Паркийн нэгж, тоо	0	<ul style="list-style-type: none"> ▪ “Натур ларикс вүүд” ХХК нь Багануур дүүргийн 3 дугаар хороонд мод бэлтгэлийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үндсэн түүхий эд болон үйлдвэрлэлийн явцаас хаягдах түүхий эд материалаар зиг-заг хавтан, модны үртсэн блок, тавилгын үйлдвэр зэрэг чиглэлээр цогц кластер үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой. Паркийн хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд нэгжээр элсэхээр хамтран ажиллах санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Кластер үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил явагдаж байна. ▪ Мөн Багануур “Мах маркет” ХХК нь Багануур дүүргийн 3 дугаар хороонд малын махаар бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд өдөрт 200 бод, 1000 бог төхөөрч, боловсруулах хүчин чадалтай экспортын чиглэлтэй үйлдвэр юм. Үйлдвэрлэлийн явцаас хаягдах дайвар түүхий эдэд тулгуурлан Паркийн хүнсний үйлдвэрлэлийн бүсэд дайвар боловсруулах, яс боловсруулах, малын тэжээл бэлтгэх, муур нохойн хоол үйлдвэрлэх зэрэг экспортын үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэхээр хамтран ажиллах санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Кластер үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил явагдаж байна. ▪ Паркийн хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд Үнэт дулаан ХХК нь нүүрс хийжүүлэх технологийг уурын зууханд нэвтрүүлэх үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулан Эрчим хүчний яамны зөвлөлийн хурлаар батлуулахаар хүргүүлсэн. ▪ Трий трийлэнгс ойл ХХК нь 2025.07.05-ны өдөр “Үйлдвэрлэл, технологийн парк” ХХК-тай Хүрэн нүүрснээс 	30

						<p>коксжуулсан нүүрс, синтетик газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийн хүрээнд санамж бичиг байгуулан төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж байна.</p> <p>Дээрх 4 үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хянаж баталгаажуулсны дараа Паркийн нэгжийн удирдлагатай байгуулах гэрээ, Паркийн нэгжид газар ашиглуулах гэрээ байгуулахаар төлөвлөж байна.</p>	
4.3	Компанийн парк ашиглалтын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> ▪ Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 2025.02.11-ний өдрийн 01-04/716 дугаар, 2025.02.13-ны өдрийн 01-05/800 дугаар албан бичгүүдээр “Нүүрс химийн цогцолбор” байгуулах 363 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах болсныг мэдэгдсэн. ▪ МУ-ын ЗГ-ын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 139 дүгээр тогтоолын төслийг хэлэлцэн баталсан. Үүнд паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн 97,1 га болон 200 га нийт 297.1 га газар багтсан тул улсын тусгай хэрэгцээнд авсан. ▪ Паркийн 2025.03.25-ны өдрийн 57, 2025.05.21-ны өдрийн 74 дугаар тус тус албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 297.1 га газрыг солин нөхөн олгож, тус газарт хийгдсэн дараах ажлуудыг шинээр хийлгэх төсвийн хамт шийдвэрлэж өгнө үү хэмээн хүсэлтээ уламжилсан. <ul style="list-style-type: none"> ▪ Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, ▪ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ ▪ Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа ▪ Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд саналыг тусгуулж НИТХ-ын 2025.07.09-ний өдрийн 25/107 тоот захирамжаар 297.2 га олгогдсон. Нийслэлийн ЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газар газрын гэрчилгээний захирамжийн төслийг гаргаж өгөхөөр ажиллаж байна. ▪ Мөн паркийн эзэмшил 614 га газрын Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны хугацаа дууссан тул Гранд Амур ХХК-тай гэрээ байгуулан шинэчлэх ажил эхэлсэн бөгөөд 2025.09.28-ны өдөр хүлээн авахаар хамтран ажиллаж байна. 	80

4.4	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу ТУЗ-ийн хурлаар паркад тулгамдаж буй асуудлуудыг дэвшүүлэн хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хамтран ажиллах	-	ТУЗ хуралын тоо	0	4-8	<ul style="list-style-type: none"> ▪ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 4 удаа хуралдаж ТУЗ-ийн тогтоол – 14, Хурлын тэмдэглэл – 4 баталгаажсан. ▪ ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүгнэлт – 3, хурлын тэмдэглэл – 1 баталгаажсан байна. ▪ Тулгамдаж буй дараах асуудлуудыг тавьж шийдвэрлэх шатанд хэрэгжиж байна. <ol style="list-style-type: none"> 1. Компанийн албан хаагчдын ажиллах техник тоног төхөөрөмж: 2025.08 сард Нийслэлийн Мэдээлэл, технологийн газраас 14 компьютер, 5 принтер шийдвэрлэсэн. 2. Компанийн болон ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төсөв: 2025.06.25-ны өдрийн 107 дугаар албан бичгээр нийслэлийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст 109,2 сая төгрөгийн төсвийг тодотгоолоор нэмүүлэх саналыг хүргүүлсэн. НИТХ-ын 2025 оны 25/106 дугаар тогтоолоор 100,0 сая төгрөг батлагдсан. 3. Дэд бүтцийн бүтээн байгуулалт: 20 тэрбум орчим төгрөгийг 2026 оны нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна. 	100
4.5	Компанийн Хувьцаа эзэмшигч болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс нийтэд мэдээлэх шаардлагатай гэж үзсэн мэдээллийг ил тод нээлттэй хүртээмжтэй байдлаар мэдээлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<p>Мэдээллийн нээлттэй ил тод хүртээмжтэй байдлыг хангах үүднээс ТУЗ-ийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг дараах хэрэгслүүдийг ашиглан байршуулж хүргэсэн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Компанийн албан ёсны веб сайт ▪ Компанийн албан ёсны пэйж хуудас ▪ 24tsag.mn ▪ Ulaanbaatar.mn ▪ Livetv.mn ▪ Өдрийн сонин 	100
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэнэ.							
5.1	Албан хэрэг хөтлөлтийн журам стандартын дагуу баримт бичгийг боловсруулж хугацаанд нь шийдвэрлэх, албан хаагчдын албан хэрэг хөтлөлтөд хяналт тавьж, хадгаламжийн нэгжийг бүрдүүлэх, хүлээн авах, архивын үйл ажиллагааны зааврын дагуу хөтлөн явуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<p>2025.01.01-2025.09.25 ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Нийт ирсэн бичгийн тоо: 198 ▪ Хариутай-53 ▪ Хугацаандаа шийдвэрлэсэн-42 ▪ Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-7 ▪ Хугацаа хэтэрч шийдвэрлээгүй-0 ▪ Судалж байгаа-4 ▪ Хугацаа дөхсөн-1 ▪ Хариугүй-145 ▪ Хугацаандаа хаасан-144 	100

						<ul style="list-style-type: none"> ▪ Нийт 198 албан бичиг ирснээс хариутай 53, хариугүй 145 бичиг ирсэн. Хариутай албан бичгийн шийдвэрлэлт 92.86%, хариугүй албан бичгийн шийдвэрлэлт 99.66% байна. Шийдвэрлэлтийн хугацаа 5.12 хоног байна. ▪ Нийслэлийн Архивын газраас гаргасан хуваарийн дагуу 2025.10.17-ны өдөр зохион байгуулагдах Архивын улсын үзлэгийн бэлтгэлийг ханган ажиллаж байна. 	
5.2	Иргэдтэй хийх уулзалтыг биечлэн болон цахимаар зохион байгуулж, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгөх, зөрчилгүй ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<p>2025.03.25-ны өдрийн 54 дугаар албан бичгээр компанийн 1 дүгээр улиралд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлийн тайлан мэдээг хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Ажилд орох хүсэлт – 8 ▪ Ажлаас чөлөөлөгдөх хүсэлт – 5 <p>2025.03.25-ны өдрийн 56 дугаар албан бичгээр компанийн 1 дүгээр улирал иргэд, аж ахуй нэгжтэй уулзсан тайлан мэдээг хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Иргэдийн уулзалт – 13 ▪ Аж ахуй нэгж уулзалт – 1 	100
5.3	Гадаад харилцааны үйл ажиллагааг өргөжүүлэн, олон улсын хөрөнгө оруулагч, шинэ дэвшилтэт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа, форумд нээлттэй ил тод оролцох, сурталчлах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> ▪ Японы эрчим хүч, хүрээлэн буй орчны салбарын утаанаас салах бодлогод чиглэсэн Монгол Улсад ирээдүйд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дэвшилтэт технологийн тухай, Монгол, Японы холбогдох талуудын хооронд харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжуудыг нээх зорилготой айлчлалын хөтөлбөрт Дарга Ч.Элбэгсайхан томилолтоор ажилласан. ▪ БНХАУ, БНСУ-ын томоохон компаниуд, хөрөнгө оруулагчдын мэдээллийг интернет эх сурвалжаас түүвэрлэн, хэсэгчилж орчуулан, тойм мэдээлэл бэлтгэсэн. Холбоо барих мэдээллийг ашиглан хамтран ажиллах боломжийн талаарх товч мэдээллийг бэлтгэж, компанийн танилцуулгын хамт, дээрх компаниуд, хөрөнгө оруулагчдын холбоо барих хаяг руу буюу цахим хаягаар хүргүүлсэн. ▪ Компанийн танилцуулгыг Монгол, Англи, Солонгос, Хятад хэл дээр бэлтгэн холбогдох сурталчилгаа, үйл ажиллагаанд ашиглаж байна. ▪ БНСУ-ын үйлдвэрлэл, технологийн паркуудын хөгжсөн түүхийг интернет эх сурвалжаас түүвэрлэн цуглуулж, орчуулж байна. ▪ Компанийн үйл ажиллагааг хөгжүүлэн өргөжүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, мэдээлэл хүргэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, өндөр хөгжсөн үйлвэрлэл, технологийн паркуудтай биечлэн танилцах, туршлага судлах хүрээнд төсөл, 	100

						<p>хөтөлбөрүүдэд оролцох боломжоор хангагдах, дэмжлэг туслалцаа авах хүсэлтийг Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, Нийслэлийн Засаг даргын Гадаадын хөрөнгө оруулалт хариуцсан орлогч С.Батырбек нарт хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зарлан зохион байгуулдаг үзэсгэлэн, чуулга уулзалтуудын хуваарь, холбогдох мэдээллийг нэгтгэн гаргаж, дээрх арга хэмжээнүүдэд хамрагдах боломжийг эрэлхийлж байна. 	
5.4	<p>Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж, Компанийн санхүүжилт, ногдол ашиг болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, байгууллагын санхүүгийн баримт бичгийг www.shilendans.mn сайтад агуулга стандартын дагуу байршуулах</p>	Нийслэлийн төсөв 600.0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> 2025.01.30-ны өдрийн 31 дугаар албан бичгээр НӨХГ-т байгууллагын эзэмшилд 2024 онд ирсэн Land Cruiser-200 УНИ0164 дугаартай авто машины ашиглалт, засвар үйлчилгээ болон бензин шатахууны зардал 2025 оны төсөвт батлагдаагүй тул буцааж хүлээлгэн өгөх тухай хүсэлт гаргаж хүлээлгэн өгсөн. 2025.02.06-ны өдрийн 35 дугаар албан бичгээр НЗДТГ-т НИТХ-ийн 2024 оны 24/33 дугаар тогтоолоор дүрмийн сангийн хөрөнгө 600.0 сая төгрөгийн санхүүжилтийн олгох тухай захирамжийн саналыг хуудсыг авч холбогдох удирдлагуудаар хянуулан 2025.02.14-ний өдрийн Санхүүжилтийг олгох тухай А/232 дугаар захирамж гарсан. Нийслэлийн дотоод аудитын албанаас 2025.03.31-ний өдөр 2/68 дугаар албан бичгээр 2023, 2024 оны дотоод аудит, хяналт шалгалтын тайланг ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, зөвлөмжийн тайланг 2025.06.10-ны өдөр цахимаар, 2025.06.25-ны өдрийн дотор албан бичгээр хүргүүлсэн. www.shilendans.mn сайтад хуулийн дагуу хугацаанд нь нийт 124 мэдээ, тайланг байршуулсан. НЗДТГ-ын 2025.04.09-ний өдрийн 03/2131 дугаар 2026 оны төсвийн төсөлд саналаа хүргүүлсэн. Хаан банканд 2025.05.16-ны өдөр арилжааны данс нээлгэж албан хаагчид болон ТУЗ-ийн гишүүдийн 1-5 сарын цалинг олгосон бөгөөд санхүүгийн үйл ажиллагаа жигдэрсэн. Компанийн санхүүгийн 2025 оны хагас жилийн тайлан гаргаж Санхүү төрийн сангийн хэлтсээр хянуулсан. 2025.03.13-ны өдрийн 48 дугаар албан бичгээр Хаан банканд хүсэлт гаргаж иж бүрэн I5 компьютер шийдвэрлүүлж, хүлээн авсан. 2025.08.08-ны өдөр Нийслэлийн Мэдээлэл, технологийн газраас 14 компьютер, 5 принтер хүлээн авсан. 	100

						<ul style="list-style-type: none"> 2025.06.25-ны өдрийн 107 дугаар албан бичгээр нийслэлийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст 109,2 сая төгрөгийн төсвийг тодотголоор нэмүүлэх саналыг хүргүүлсэн. НИТХ-ын 2025 оны 25/106 дугаар тогтоолоор 100,0 сая төгрөг батлагдсан бөгөөд 2025.08.29-ны өдрийн А/1214 дугаар Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан. 	
5.5	Компанийн мэдээллийн нээлттэй байдал (үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг ханган, цахим хуудасны баяжилтыг хуулийн хугацаанд зохион байгуулж ажиллах)	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг заасны дагуу байнга ил тод, нээлттэй байлгах 5 бүлгийн 87 төрлийн мэдээллийг shilen.gov.mn системд хагас жилийн байдлаар 6 сард оруулан 79% дүгнэгдсэн бөгөөд компанийн 3 дугаар улирлын мэдээ мэдээллийг 2025.09.25-ны дотор нэгтгэн оруулсан. Компанийн албан ёсны пайж хуудсанд 3 дугаар улирлын байдлаар рийл-65, постер-52, фото мэдээ-235, нийт 352 удаа мэдээллийг байршуулсан. erp.ulaanbaatar.mn цахим системд 7 удаа үйл ажиллагааг сурталчлан таниулах мэдээллийг байршуулсан. http://baganuur-itp.mn/ сайтад дотоод үйл ажиллагаа-26, цаг үеийн мэдээлэл-40, сул ажлын байрны зар-5, хүний нөөцийн дүрэм, журам-9, алсын хараа, эрхэм зорилго-2, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан-22, паркийн танилцуулга-1, паркийн үндсэн нэгжүүдийн мэдээ-5, бүтэц, орон тоо--1, бодлогын баримт бичиг-4 нийт 115 удаагийн нийтлэлийг байршуулан ажиллалаа. Багануур үйлдвэрлэл, технологийн парк пэйж хуудсанд 14 мега төсөл болон нийслэлийн чухал мэдээ мэдээллийг тогтмол иргэдэд өгч ажилласан. 	100
Зорилт 6. 2025 он - Бүтээн байгуулалтын жил. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамж							
6.1	Нийслэлийн "Бүтээн байгуулалтын жил" зорилтот жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж улирал бүр дээд газарт тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	0	100	<ul style="list-style-type: none"> Бүтээн байгуулалтын жилийн хүрээнд дараах 2 ажил хийгдэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76 км өндөр хүчдэлийн агаарын шугамын бүтээн байгуулалтын ажил 2022-2024 он дамнан хэрэгжиж амжилттай дууссан. Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай дэд станцын ажлын гүйцэтгэгчээр Эм Ай Эс Эс ХХК шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан. 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр "Эм Ай Эс Эс" ХХК-аас дэд станцын бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан газар дээр 	100

						ирж ажилласан бөгөөд ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох байгууллагад хүргүүлэн хүлээгдэж байна.		
							Биелэлт	82,5%



ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-ИЙН
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ⁶⁶³ Б.БЯМБАЦЭЦЭГ

НЭГТГЭСЭН:
 ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
 ДАРГА *Б. Мичид* Б.МИЧИД-ЭРДЭНЭ